



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ**

2015 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А-110

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр нь урамшуулах тухай журмыг нэгдүгээр, идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах гэрээний загварыг хоёрдугаар, идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэх, энгэрийн тэмдгийн загварыг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Идэвхтэн байгаль хамгаалагчийг ажлын удирдамж, ажиллах нөхцөл бололцоогоор хангах;

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А-115 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д. ОЮУНХОРОЛ

Байгаль орчин, ногоон хөгжил,
аялал жуулчлалын сайдын
2015 оны 02 дугаар сарын 26 ны өдрийн
А-110 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ИДЭВХТЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ АЖИЛЛУУЛАХ, АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР НЬ УРАМШУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Байгаль орчныг хамгаалах, түүний нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг тухайн орон нутагт хэрэгжүүлэхэд байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид туслах үүрэг бүхий идэвхтэн байгаль хамгаалагчийг ажиллуулах, ажлын үр дүнгээр нь урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Байгалийн ховор ба ховордсон, их хэмжээгээр ашигладаг нөөц баялгийг хамгаалах зорилгоор түүний тархац, нутгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцсан идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж болно.

1.3. Улсын тусгай хамгаалалттай нутагт ажиллах идэвхтэн байгаль хамгаалагчдын хариуцах нутаг дэвсгэрийн хэмжээг тухайн хамгаалалтын захиргааны дарга тогтооно.

Хоёр. Идэвхтэн байгаль хамгаалагчид тавигдах шаардлага

2.1. Идэвхтэн байгаль хамгаалагч дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1. ял шийтгүүлж байгаагүй, 18 насанд хүрсэн байх;

2.1.2. бүрэн дундаас дээш боловсролтой;

2.1.3. тухайн нутгийн оршин суугч байх.

Гурав. Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулахаар гэрээ байгуулах

3.1. Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулахаар тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болгосон иргэний материалыг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн нэгж нь хянан энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан иргэнтэй гэрээ байгуулна.

3.2. Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулахаар тухайн тусгай хамгаалалттай нутгийн орчны зөвлөлөөс санал болгосон иргэний материалыг тухайн тусгай хамгаалалттай нутгийн хамгаалалтын захиргаа нь хянан энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан иргэнтэй гэрээ байгуулна.

3.3. Энэ журмын 3.1, 3.2-т заасан эрх бүхий этгээд идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулахаар санал болгосон иргэнтэй гэрээ байгуулахаас татгалзах үндэслэл байгаа бол тайлбарлаж, хариу мэдэгдсэн байна.

3.4. Идэвхтэн байгаль хамгаалагчид үнэмлэх, энгэрийн тэмдгийг гэрээ байгуулсан албан тушаалтан олгоно.

3.5. Идэвхтэн байгаль хамгаалагч нь гэрээний хугацаа дуусмагц идэвхтэн байгаль хамгаалагчийн энгэрийн тэмдгийг буцаан өгнө.

3.6. Идэвхтэн байгаль хамгаалагч нь байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор дараах үйл ажиллагаа явуулна:

3.6.1. иргэдийн ан агнах, байгалийн нөөц баялгийг ашиглах зөвшөөрөл, төлбөр, хураамж төлсөн эсэхийг шалгаж, ашиглалт явуулах газар нутгийг зааж өгөх;

3.6.2. зохих зөвшөөрөлгүй буюу төлбөр, хураамжаа төлөөгүй иргэдийн ан агнах, байгалийн нөөц баялаг ашиглах үйл ажиллагааг нь зогсоож, тухайн нутгаас гарч явахыг шаардах;

3.6.3. байгалийн нөөц баялгийг хууль бусаар ашигласан, агнасан, олборлосон үйлдэлд акт бичиж баримтжуулах;

3.6.4. байгалийн нөөц баялгийг хууль бусаар ашигласан, агнасан, олборлосон тухай мэдээллийг нэн даруй хүргүүлэх;

3.6.5. ой, хээрийн түймэр, үер, усны аюул зэрэг гамшиг тохиолдох үед тэр тухай мэдээллийг цаг алдалгүй дамжуулах, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг шуурхай авах;

3.6.6. хариуцсан нутаг дэвсгэрийнхээ нөөц баялгийг иргэд ахуйн хэрэгцээндээ хэрэглэх тохиолдолд түүний газар нутаг, хил хязгаарыг зааж өгөх, зөвлөгөө өгөх;

3.6.7. хог хаягдлын нэгдсэн цэг тогтоолгох, зориулалтын газарт хаяж байгаа эсэхийг шалгах;

3.6.8. усны сан бүхий газрын онцгой, эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх;

3.7. Идэвхтэн байгаль хамгаалагч жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор тухайн жилд хийсэн ажлынхаа тайланг өөрийн томилсон албан тушаалтанд хүргүүлнэ.

Дөрөв.Идэвхтэн байгаль хамгаалагчийг урамшуулах

4.1. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн нэгж, Тусгай хамгаалалттай нутгийн хамгаалалтын захиргаанаас идэвхтэн байгаль хамгаалагчийг ажлын үр дүнгээр нь шагнан урамшуулахдаа дараах зарчмыг баримтална:

4.1.1. байгалийн нөөц баялгийг хууль бусаар бэлтгэсэн, агнасан, түүсэн тухай мэдээлсэн, илрүүлсэн, энэ журмын 3.6.8-д заасан зөрчлийг илрүүлж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлэхэд идэвх зүтгэл гарган

ажилласан бол идэвхтэн байгаль хамгаалагчийг тухайн зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн 15 хувиар тус тус шагнаж урамшуулна.

4.2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн нэгж, Тусгай хамгаалалттай нутгийн хамгаалалтын захиргааны дарга нар идэвхтэн байгаль хамгаалагчийн ажлыг жил тутам дараах үзүүлэлтээр дүгнэнэ:

4.2.1. илрүүлсэн хэрэг зөрчлийн тоо;

4.2.2. байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн бууралт;

4.2.3. мэдээлэл өгч арга хэмжээ авхуулсан хэрэг зөрчлийн тоо, хэмжээ.

4.3. Энэ журмын 4.2-т заасан үзүүлэлтээр хамгийн өндөр амжилт гаргасан 5 байгаль хамгаалагчийг жил тутам шалгаруулж байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний нэрэмжит шагналаар шагнана.

4.4. Байгалийн нөөц баялгийг хууль бусаар бэлтгэсэн, түүсэн, агнасны улмаас учирсан хохиролд тавигдсан нөхөн төлбөрөөс байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгийн 15 хүртэл хувиар тухайн зөрчлийг илрүүлэн, нөхөн төлбөрийг барагдуулахад идэвх зүтгэл гарган ажилласан идэвхтэн байгаль хамгаалагчийг урамшуулна.

4.5. Сум, дүүргийн Засаг дарга өндөр амжилт гаргасан 1, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн нэгжийн дарга 3 хүртэл идэвхтэн байгаль хамгаалагчийг жил тутам шалгаруулан нэрэмжит шагналаар шагнаж байна.

4.6. Идэвхтэн байгаль хамгаалагчийг унаа, бие хамгаалах болон холбооны хэрэгслээр хангах үүргийг сум, дүүргийн Засаг дарга, тухайн тусгай хамгаалалттай нутгийн хамгаалалтын захиргааны дарга хариуцан хэрэгжүүлнэ.

Байгаль орчин, ногоон хөгжил,
аялал жуулчлалын сайдын
2015 оны 02 дугаар сарын 26 ны өдрийн
А-110 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ИДЭВХТЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭ

..... Дугаар
/аймаг/ хот /огноо/

Нэг талаас
(Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах байгууллагын нэр)

түүнийг үндсэн дээр төлөөлөн
(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

нөгөө талаас хаягаар оршин
суух тоот иргэний үнэмлэхтэй тоот регистрийн дугаартай
..... нар нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15
дугаар зүйлийн 15.1.14 дэх заалтыг үндэслэн 20... оны сарын-ны өдөр хэлэлцэн
тохирч, энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулж байна.

1. Гэрээний үндсэн нөхцөл

- 1.1. Эрхлэх ажил - Идэвхтэн байгаль хамгаалагч
- 1.2. Гүйцэтгэх ажлын чиглэл - Байгаль орчныг хамгаалах, түүний нөөц баялгийг зохистой ашиглуулах, нөхөн сэргээлгэх
- 1.3. Ажлын газрын байршил
- 1.4. Урамшуулал
- 1.5. Идэвхтэн байгаль хамгаалагчаар ажиллах гэрээний хугацаа

2. Гэрээний нэмэгдэл нөхцөл

- 2.1. Хөдөлмөрийн гэрээний хугацаа сунгах тохиолдол
- 2.2. Сахилгын ноцтой зөрчилд тооцон хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах тохиолдол
- 2.3. Бусад.....

3. Байгууллагын хүлээх үүрэг

- 3.1. Гэрээ байгуулсан үеэс нь байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч шаардлагатай зааварчилгааг идэвхтэн байгаль хамгаалагчид өгч ажиллана.

- 3.2. Идэвхтэн байгаль хамгаалагчийн ажил үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатайдуран, зургийн аппарат г.м) багаж хэрэгслээр хангана.
- 3.3. Идэвхтэн байгаль хамгаалагчийн санал хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэж хариу өгнө.
- 3.4. Идэвхтэн байгаль хамгаалагчийн хэвийн ажиллах нөхцөлөөр нь хангана.
- 3.5. Идэвхтэн байгаль хамгаалагчийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд тусална.

4. Идэвхтэн байгаль хамгаалагчийн хүлээх үүрэг

- 4.1. байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ чанд биелүүлэхийн тулд байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагчид туслах үүрэгтэй ажиллана.
- 4.2. Мэргэжил, ур чадвараа байнга дээшлүүлэн идэвх санаачлагатай ажиллана.
- 4.3. Энэхүү гэрээний 3.2-т заасан ёсоор олгосон хувцас, багаж, хэрэгслийг норм, ашиглах журмын дагуу эдэлнэ.
- 4.4. Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах гэрээний хугацаа дуусмагц идэвхтэн байгаль хамгаалагчийн энгэрийн тэмдгийг буцаан өгнө.
- 4.5. Идэвхтэн байгаль хамгаалагчийн буруугаас учруулсан эд хөрөнгийн хохирлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан үндэслэлийн дагуу нөхөн төлнө.

5. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1. Байгууллага үүргээ биелүүлээгүйгээс идэвхтэн байгаль хамгаалагчид учруулсан хохирлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу арилгана.
- 5.2. Энэхүү гэрээний 2.2-т заасан зөрчил гаргасан Идэвхтэн байгаль хамгаалагчтай байгуулсан гэрээгээ захиргаа цуцална.

Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах гэрээ байгуулсан:

Байгууллага:

Идэвхтэн байгаль хамгаалагч:

Нэр, хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(Тамга, тэмдэг)

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 22 дугаар сарын 26-ны өдрийн А-110 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ИДЭВХТЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙН ҮНЭМЛЭХ, ЭНГЭРИЙН ТЭМДЭГИЙН ЗАГВАР

130 см



55см

Идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэх №



..... овогтой
..... нь аймгийн
..... сумын
ИДЭВХТЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ мөн.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Олгосон _____ оны _____ сарын _____ өдөр

Идэвхтэн байгаль хамгаалагч нь байгаль орчин хамгаалахад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд туслэх үүрэгтэй бөгөөд байгалийн байрлал ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжийн байранд нэвтрэх, гарчгах, төлбөр тооцооны хялбардололтой байр баримтуудыг шалгах тэмцэх, үүрэг бус үйлдлийн талаар сум, багийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчдад мэдэгдэж шалгуулах эрхтэй.

The Volunteer Ranger shall have responsible of assisting in implementation of state control on nature protection and right to entry into the workplace of citizens, organizations or business entities who utilizing natural resources and carry out inspection on certification, permission and building documents and to inform regarding the environmental violations to the governors of relative soum and aimags and state inspectors, environmental rangers and to inquire in carrying out inspection.

Хуучинтай хугацаа: _____

Идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэх №



..... овогтой
..... нь аймгийн
..... сумын
ИДЭВХТЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ мөн.

БАЙГААЛАЛТЫН ЗАХИГААНЫ ДАРГА


Олгосон _____ оны _____ сарын _____ өдөр

Идэвхтэн байгаль хамгаалагч нь байгаль орчин хамгаалахад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд туслэх үүрэгтэй бөгөөд байгалийн байрлал ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжийн байранд нэвтрэх, гарчгах, төлбөр тооцооны хялбардололтой байр баримтуудыг шалгах тэмцэх, үүрэг бус үйлдлийн талаар сум, багийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчдад мэдэгдэж шалгуулах эрхтэй.

The Volunteer Ranger shall have responsible of assisting in implementation of state control on nature protection and right to entry into the workplace of citizens, organizations or business entities who utilizing natural resources and carry out inspection on certification, permission and building documents and to inform regarding the environmental violations to the governors of relative soum and aimags and state inspectors, environmental rangers and to inquire in carrying out inspection.

Хуучинтай хугацаа: _____

Идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэх №



..... овогтой
..... нь аймгийн
..... сумын
ИДЭВХТЭН БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ мөн.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Олгосон _____ оны _____ сарын _____ өдөр

Идэвхтэн байгаль хамгаалагч нь байгаль орчин хамгаалахад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд туслэх үүрэгтэй бөгөөд байгалийн байрлал ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжийн байранд нэвтрэх, гарчгах, төлбөр тооцооны хялбардололтой байр баримтуудыг шалгах тэмцэх, үүрэг бус үйлдлийн талаар сум, багийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчдад мэдэгдэж шалгуулах эрхтэй.

The Volunteer Ranger shall have responsible of assisting in implementation of state control on nature protection and right to entry into the workplace of citizens, organizations or business entities who utilizing natural resources and carry out inspection on certification, permission and building documents and to inform regarding the environmental violations to the governors of relative soum and aimags and state inspectors, environmental rangers and to inquire in carrying out inspection.

Хуучинтай хугацаа: _____

6.7см



6.7см